



ДОГСОМЫН ЦЭДЭВ

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга
1965-1971 он

Хуучин Засагт хан аймаг Баатар вангийн хошуу одоогийн Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын нутагт 1930 онд төрсөн. Тэрбээр 1940-1949 онд бага сургууль, Санхүү эдийн засгийн техникум, 1953-1957 онд ЗХУ-ын Иркутск хотын Санхүү эдийн засгийн дээд сургууль төгсжээ.

1949-1953 онд Сангийн яаманд байцаагч, зааварлагч, ахлах зааварлагч, 1957-1959 онд Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд Санхүүгийн хэлтсийн дарга, 1959-1962 онд хотын гүйцэтгэх захиргаанд төлөвлөгөөний комиссын дарга бөгөөд захиргааны нэгдүгээр орлогч дарга, 1962-1965 онд Улаанбаатар хотын намын хороонд барилга, тохижилт үйлчилгээ эрхэлсэн нарийн бичгийн дарга, 1965-1971 онд Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх

захиргааны дарга, 1971-1974 онд БНМАУ-аас БНБАУ-д Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, 1974-1978 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан "Монголсовцветмет" нэгдлийн ерөнхий захирлын нэгдүгээр орлогч, 1978-1981 онд Хөнгөн хүнсний үйлдвэрүүдийн өргөтгөл, шинэтгэл эрхэлсэн МАХН-ын Төв Хороо, Засгийн газрын төлөөлөгч, 1981- 1987 онд Сүхбаатарын районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, 1988-1990 онд Улсын нэгдсэн тусгай II эмнэлгийн санхүү-аж ахуй эрхэлсэн орлогч даргаар тус тус ажиллаж байсан. Тэрбээр МАХН-ын XIV, XV, XVI, XVII, МҮЭ-ийн VIII, IX их хурлуудад оролцон, Намын ХҮ1, XVII их хурлаас Намын Төв Хорооны орлогч гишүүн, МҮЭ-ийн VIII, IX Их Хурлаас Төв Зөвлөлийн гишүүн, АИХ-ын VI, VII дахь удаагийн сонгуулиар АИХ-ын депутат, хот, районы Намын хорооны болон товчооны гишүүн, депутат, Гүйцэтгэх захиргааны гишүүнээр удаа дараа сонгогджээ.

Түүний хөдөлмөр бүтээлийг төр засаг үнэлж, төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн гавьяаны" болон "Алтан гадас" одон бусад ойн медалиуд, Болгар улсын "Мадарски Коньнин" 1 дүгээр зэргийн одон, ЗХУ, Болгарын бусад ойн медалиудаар шагнажээ.